



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 06 өдөр

Дугаар A/75

Баян-Адарга сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дахь заалт, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 26-ний өдрийн А/105 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх Ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Н.Ганбат	Засаг даргын Орлогч
Нарийн бичгийн дарга:	Ө.Энхзул	Газрын даамал
Гишүүдэд:	Ц.Цэрэндулам	Байгаль орчны Улсын хяналтын байцаагч
	Б.Энх-Ариунаа	Бэлчээр хариуцсан мэргэжилтэн
	О.Батсуурь	Байгаль хамгаалагч
	Г.Намсрай	Сайхан багийн Засаг Дарга
	Н.Цолмонбаяр	Адарга багийн Засаг Дарга
	Г.Жавзмаа	Жаргалант багийн Засаг Дарга
	М.Нямдорж	Дуурлиг багийн Засаг Дарга

2.Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын гүйцэтгэлийн тайланг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний дотор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хүргүүлж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

3.Ажлыг гүйцэтгэхэд шаардагдах 400,000 төгрөгийн зардлыг Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Г.Бишүүгармаа)-д зөвшөөрсүгэй.

4.Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Орлогч (Н.Ганбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  О.ДХАГВАДОРЖ

